



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургуулийн спорт заалны барилгыг буулгаж, шинээр усан бассейн бүхий спорт заал барих болсонтой холбогдуулан тус сургуулийн баланст бүртгэлтэй нийт 165,555,284.00 (нэг зуун жаран таван сая таван зуун тавин таван мянга хоёр зуун наян дөрөв) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 64,024,247.80 (жаран дөрвөн сая хорин дөрвөн мянга хоёр зуун дөчин долоон төгрөг наян мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан спорт заалны барилгыг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн
123 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Спорт заал	46	м2	288	111,824,317.00	111,824,317.00	25,414,617.60	86,409,699.40
2	Цементэн суурьтай төмөр хашаа	9	м2	425	13,266,375.00	13,266,375.00	3,491,151.60	9,775,223.40
3	Зүлэгжүүлсэн талбай	9	м2	1535	18,312,550.00	18,312,550.00	18,312,550.00	-
4	Хар мод	31	ш	64	1,860,800.00	1,860,800.00	930,398.72	930,401.28
5	Бут сөөг	31	ш	708	3,060,000.00	3,060,000.00	1,530,026.16	1,529,973.84
6	Төмөр хашаа	5	м2	264	2,332,714.00	2,332,714.00	1,943,935.72	388,778.28
7	Гүйлтийн зам талбай	9	м2	792	8,239,968.00	8,239,968.00	8,239,968.00	-
8	Биеийн тамирын талбай	5	м2	240	6,658,560.00	6,658,560.00	4,161,600.00	2,496,960.00
НИЙТ ДҮН						165,555,284.00	64,024,247.80	101,531,036.20